

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИН ХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арваннэгдүгээр сарын 5-ны 14 цаг 05 минутад эхэлж, 14 цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 15 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Дундговь, Архангай, Төв аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 10 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд Дундговь аймаг, Архангай аймаг, Төв аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Дундговь аймаг, Архангай аймаг, Төв аймагт 10 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 92 иргэн /Дундговь аймагт 22, Архангай аймагт 51, Төв аймагт 19/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 4, 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 42 иргэн /Дундговь аймагт 13, Архангай аймагт 5, Төв аймагт 24/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8, 9 дүгээр</p>

		<p>хавсралтад дурдсан нэр бүхий 20 /Дундговь аймагт 11, Архангай аймагт 4, Төв аймагт 5/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 10, 11, 12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 15 иргэн /Дундговь аймагт 4, Архангай аймагт 1, Төв аймагт 10/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 7-12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 35 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлд, Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл /Б.Лхагвасүрэн/-д, Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөл /Д.Нямдорж/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчлөн батлах. Үүнд:</p> <p>1) Төрийн нарийн бичгийн дарга,</p>

		<p>2) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 3) Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 4) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, 5) Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга, 6) Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, 7) Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, 8) Худалдааны бодлого зохицуулалтын газрын дарга, 9) Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн.</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 65 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА